



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#5 (26)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

V сар

**ОЛОН УЛСЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ**
(Нүүр 1-2)



**СУДАЛГАА
ОРОН НУТАГТ**
(Нүүр 3-4)



**СУРГАЛТ
ОРОН НУТАГТ**
(Нүүр 5)



**ТӨРӨЛЖСӨН АХЛАХ
СУРГУУЛИЙН ТУРШИЛТ**
(Нүүр 6-8)




“МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ-2024” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

“Монгол Хүүхдийн хөгжил - 2024” сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгууллаа. Тус хуралд 4 орны их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөл эрдэмтэн судлаачид оролцов.



Хурлын зорилго нь “МОНГОЛ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДАР, ЭРҮҮЛ МЭНД, ТАНИН МЭДЭХҮЙ, ХЭЛ ЯРИА, НИЙГЭМШЛИЙН ХӨГЖИЛ ТӨЛӨВШЛИЙН ХҮРЭЭНИЙ СУДАЛГАА”-ны үр дүнгийн талаар оролцогчид харилцан туршлага мэдээллээ солилцох, түгээн сурталчлах юм.

“Монгол Хүүхдийн хөгжил -2024” сэдэвт Олон Улсын эрдэм шинжилгээний хуралд 32 илтгэл ирүүлснээс 18 илтгэл хэлэлцэгдлээ.



Энэхүү хурал нь цаашдаа хүүхдийн хөгжлийн судалгааны арга зүй, үйл явцыг олон улсын хүрээнд хэлэлцдэг, гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачид харилцан туршлагаа солилцдог, тэрчлэн Монгол хүүхэд судлалын хөгжилд хувь нэмэр үзүүлэхүйц ач холбогдолтой тогтмол зохион байгуулагддаг хурал болох анхны гараа болсноороо ач холбогдол өндөртэй гэж дүгнэж байна.



БСҮХ СУДАЛГАА- ОРОН НУТАГТ



“Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн ЕБС-ийн сургалтын тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам”-ыг илрүүлэх судалгаа

Ёс зүйн туршилтын хөтөлбөрийн тохирцын судалгаа

1. Баянхонгор аймгийн төв болон Галуут, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр сумд,
2. Сүхбаатар аймгийн төв болон Түмэнцогт, Эрдэнэцагаан, Мөнххаан, Дарьганга, Онгон сумд
3. Дундговь аймгийн төв болон Адаацаг, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Хулд, Луус, Дэлгэрхангай сумд

Уг судалгаа нь онцгой нөхцөл байдлын үеийн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, цаашид сайжруулах арга замын талаар тодруулах зорилготой юм. Судалгааг орон нутгийн засаг дарга, онцгой байдлын газрын мэргэжилтэн, БШУГ-ын мэргэжилтэн, сургуулийн удирдлага, менежер, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, дотуур байрны багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нараас тоон болон чанарын аргыг хослуулан мэдээлэл цуглуулав.

Ёс зүйн хөтөлбөрийн туршилтад нийслэлийн 8 сургууль, 4 аймгийн (Орхон, Хэнтий, Дундговь, Говь-Алтай) 8 сургуулийн түүх, нийгмийн ухааны 16 багш, 10 дугаар ангийн 468 сурагч хамрагдсан.


Нийслэлийн ЧД 72-р сургуулийн 25, 24-р сургуулийн 38, ХУД 18-р сургуулийн 33, 161-р сургуулийн 25, СБД Эрдмийн хөтөч сургуулийн 27, 11-р сургуулийн 30, СХД 9-р сургуулийн 28, БГД 20-р сургууль, Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тэмүүжин сургуулийн 38, Бор-Өндөр сумын 33, Орхон аймгийн Жаргалант сумын 12, 1-р сургуулийн 33, Дундговь аймгийн Цэгц билэг сургуулийн 30, Гурвансайхан сумын сургуулийн 27, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1-р сургуулийн 35, Алтай сумын 12, нийт 468 сурагчийг хамруулав.

Энэхүү тохирцын судалгааны үр дүнд туршилтын хугацаанд хэрэгжүүлсэн “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөр нь сурагчдын ёс суртахууны хариуцлага чадамжийн хөгжилд бодитой ахиц гарсан гэж үзжээ.

БСҮХ СУРГАЛТ - ОРОН НУТАГТ




ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР
СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ



Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар Боловсролын Дэлхийн Түншлэл олон улсын байгууллагын буцалтгүй санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ” төслийн хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх арга зүй” сургалтыг ЕБС-ийн дунд ангийн нийт 2600 багш үүнээс танхимын сургалтад 1100, онлайн сургалтад 1500 орчим багш хамрагдсан.

Энэхүү сургалтыг 2024 оны 05 дугаар сард төслийн зорилтот Улаанбаатар хотын Сүхбаатар, Хан-Уул дүүрэг, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Увс аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш нар ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн судлагдахууны сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын орчинд тохируулга хийх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, суралцагчийг ахицаар үнэлэх чиглэлээр онол, дадлага хосолсон сургалтад хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур чадварт суралцаж чадавхажсан болно.





ТӨРӨЛЖСӨН АХЛАХ СУРГУУЛИЙН ТУРШИЛТЫН МЭДЭЭЛЭЛ


Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь БШУ-ы сайдын 2023 оны А/456 дугаартай тушаалын дагуу нийслэлийн 2, орон нутгийн 2, нийт 4 сургуульд математик, байгалийн ухааны төрөлжсөн ахлах сургуулийн туршилтын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг туршиж, үр дүнг тодорхойлохоор ажиллаж байна. Туршилтын хугацаанд

1 Байгалийн ухааны сургалтын хөтөлбөрт туссан агуулгаар багшид зориулсан лабораторийн хичээлийн удирдамж, сурагчид зориулсан ажлын хуудас боловсруулж, МУИС, МУБИС, ХААИС-ийн биологи, хими, физикийн лабораторид нийт 166 цагийн туршилт хичээлийг зорилтот сургуулийн сурагчдад зохион байгуулав.



2 Математикийн сургалтын хөтөлбөрт сурагчийн бие даан суралцах болон хамтарсан төсөл судалгаа хийх ажлын зааварчилгаа боловсруулж, туршлаа.

3 Бүрэн дунд боловсролын математик, байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрэглээ болон мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийн агуулгатай уялдуулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн чиглэлийн төрөлжсөн ахлах ангид туршлаа.




4 Ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлох, мэргэжил сонгоход нь дэмжлэг үзүүлэх, нийгмийн идэвхтэй иргэн төлөвшүүлэх зорилго бүхий бүтээлч үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгэн хувилбарыг боловсруулж, туршсан нь сурагчдыг өөрийн удирдлагатай, цагийн нарийн төлөвлөлттэй ажиллах, багийн ажилд өөрийн хувь нэмрээ оруулах нь чухал болохыг таниулсан үйл ажиллагаа боллоо.

- 5** Мөн зорилтот сургуулийн багшийн чадавхжуулах ментор багшийн сургалтыг зохион байгуулсан нь багшийн заах арга зүй, мэргэжлийн онолын мэдлэгийг нэмэгдүүлэхэд тустай үйл ажиллагаа боллоо.



Сэдэв сонгож багшийн чиглүүлэг дор шинжлэх ухаанч эрэл хайлт хийх туршилт судалгаа (scientific investigation) хийж, хамтарсан шинжлэх ухааны төсөл хэрэгжүүлэв.



Төрөлжсөн ахлах сургуулийн туршилтын 4 сургуульд лабораторийн хичээл заасан их, дээд сургуулийн багш нар дараах санал, дүгнэлтийг гаргалаа.

МУИС-БИОЛОГИЙН БАГШ НАР

- Лабораторийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг нөөц, хангалт, ажиглалтын менежментэд анхаарал хандуулах
- Ахлах ангийн сурагчдын сонголтыг эрт илрүүлэх
- Багш нарын туршилтат хичээлийг заах ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах

МУБИС-ХИМИЙН БАГШ НАР

- Сурагчдын туршилт үйлдэх, шинжлэх ухаанч эрэл хайгуул хийх чадварыг оношлох
- Сорил, туршилтын аюулгүйн ажиллагаа, арга техник, хэрэглэгдэх шил сав, багаж тоног төхөөрөмж зэргийг харгалзан үзэж аюулгүй, энгийн, хялбар, ажиглагдах өөрчлөлт сайтай (дүгнэлт гаргахад дөхөм болох) туршилтуудыг сонгон, дидактик боловсруулалт хийсэн туршилтын аргачлалыг ЕБС-уудад нэвтрүүлэх
- Мөн сорил, туршилтын аргачлалыг сурагчдын туршилт үйлдэх чадамжид тулгуурлан шинжлэх ухаанч эрэл хайлтын зохих түвшинд нийцүүлэн боловсруулах
- Эхний буюу 10-р ангийн 1 ба 2-р улирлын бүх сорил туршилтын аргачлалыг алгоритмын түвшинд боловсруулах, анги ахих тусам эрэл хайлтын болон бүтээлч түвшинд боловсруулж нэвтрүүлэх
- ЕБС-д нэг удаагийн оролт 90 минутаас доошгүй байх лабораторийн цаг гэдгийг гаргах
- Сонгоны ихэнх цагийг лаборатори хичээлийн хэлбэрээр оруулах
- Туршилтаас мэдлэг бүтээлгэх арга зүйг багш нарт сайтар эзэмшүүлэх

МУБИС-ФИЗИКИЙН БАГШ НАР

- ЕБС-ийн физикийн хичээлийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх,
- Багш бэлтгэдэг их дээд сургуулийн туршилтын багаж хэрэгслийг дунд сургуулийн сургалтын хөтөлбөртэй нийцүүлэн хангалт хийх
- Их, дээд сургуулийн багш нар ЕБС-ийн багштай нягт хамтран ажиллах.

ХААИС-ФИЗИК, ХИМИЙН БАГШ НАР

- ЕБС-ийн физикийн хичээлийн лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг багаар ажиллахад хүрэлцээтэй болгох, хичээлийн нэмэлт хэрэглэгдэхүүнээр хангах.

ХААИС-БИОЛОГИЙН БАГШ

- Туршилт лабораторийн ажилд хэрэглэгдэх багаж, шил сав, тоног төхөөрөмж хэрэглэх байдлаар сурагч бүрт хүрэлцээтэй байх.
- Лабораторийн зай талбай, хэмжээг бодолцон 12-15 сурагчтай хэсэг болгон хуваарилах.